ГАДНА ХАНА

ДЭЭВЭР

БАРИЛГЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ ГЭРЧИЛГЭЭ			
Бүртгэлийн дугаар:	Огнолын огноо:	Хүчлэгний хурдлага:	
117.01.0004	19.01.2024	20...	...
Барилгын өндөрлөгний байр			
Гэрлэлтийн төлөл:	Хот:	Солонгосийн нутаг:	
Бүтэцтэй барилга:	Орхон:	Улаанбаатар:	
Бүтэцтэй барилга:	АЗС:	Улаанбаатар:	
Барилгын төрөл:	Уламжлалт:		
Барилгын үйлдвэр:			
Барилгын тусламж:			
Хөдөлгөөн:	42	90.2	
Сүрьеэ:	АА 102008		
Барилгын эрчим хүчний гэрчилгээний өндөрлөг			
Барилгын эрчим хүчний гэрчилгээний өндөрлөг:	Нэр:	Төрөл:	Хэмжээ:
A++	117.01.0004	20...	...
A+			33,8 41%
A			57,7
B			
C			
D			
E			
Барилгын эрчим хүчний гэрчилгээний өндөрлөг			
Барилгын эрчим хүчний гэрчилгээний өндөрлөг:	Нэр:	Төрөл:	Хэмжээ:
117.01.0004	19.01.2024	20...	...
Барилгын эрчим хүчний гэрчилгээний өндөрлөг			
Барилгын эрчим хүчний гэрчилгээний өндөрлөг:	Нэр:	Төрөл:	Хэмжээ:
117.01.0004	19.01.2024	20...	...

- 1 - Паркетан шал δ=12
- 2 - Зөөлөгч шал δ=3
- 3 - Цементэн тэгшилгээ 65мм
- 4 - Төмөр бетон 150мм
- 5 - Гялгар цаас
- 6 - EPS дулаалга 200мм
- 7 - Гялгар цаас
- 8 - Хайрга 500мм

- 1 - Гадна засал
- 2 - Тортой шавардлага δ=15мм
- 3 - Бүрэн цутгамал төмөр бетон δ=200мм

- 1 - Чулуутай хар цаас 2-р үе
- 2 - Чулуугүй хар цаас 1-р үе
- 3 - Битум
- 4 - Цементэн тэгшилгээ 90мм
- 5 - Гялгар цаас PE
- 6 - XPS дулаалга 400-250мм
- 7 - Төмөр бетон хучилт 150мм

Зураг 14. Эрчим хүчний хэмнэлттэй 130 м² Бүрэн цутгамал амины орон сууц

Тайлбар: Цутгамал бетон хийцлэлээр эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууц барихаар төлөвлөж байгаа бол ихэвчлэн 2 болон түүнээс дээш давхар амины орон сууц барихад тохиромжтой.

Цутгамал барилга нь өртөг өндөртэй төдийгүй, мэргэжлийн барилгын хүний нөөцөөр барилгын норм стандартыг хатуу мөрдөж барих шаардлагатай.

Бетоны марк болоод даац авах дам нуруу, багана зэргийг нарийн төлөвлөх шаардлагатай. Бүрэн цутгамал барилга нь физик механикийн өндөр үзүүлэлттэй төдийгүй насжилт өндөр, температурын хийгээд ус чийгийн нөлөөлөл, газар хөдлөлтөд тэсвэртэй.

8. ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТТЭЙ АМИНЫ ОРОН СУУЦНЫ БАРИЛГЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭЛТ

- 8.1. БНБД 25-01-20 “Барилгын дулаан хамгаалалт” болон “Барилгын эрчим хүчний гэрчилгээ олгох журам”-ыг үндэслэн гэрчилгээ олгоно.
- 8.2. Зураг төсөл боловсруулах үе шатанд барилгын халаалт, агаар сэлгэлтийн дулааны эрчим хүчний хэрэгцээний нормчилсон үзүүлэлтийн тооцоог зураг төсөл боловсруулж буй архитектор, инженерүүд гүйцэтгэнэ.
- 8.3. Нормын шаардлага хангаж буй эсэхийг эрх бүхий барилгын эрчим хүчний аудиторуд хянаж барилгын эрчим хүчний гэрчилгээ олгоно.
- 8.4. Халаалт ба агаар сэлгэлтийн дулааны эрчим хүчний хэрэгцээний шаардлагын биелэлтийг ашиглалтад орсноос хойш 5-аас багагүй жил тутамд барилгын гүйцэтгэгч /захиалагч/ байгууллага хариуцан барилгын эрчим хүчний нормчилсон үзүүлэлтийн тооцоо -туршилтын хяналтыг гүйцэтгүүлнэ.
- 8.5. Эрчим хүч хэмнэлтийн “D”, “E” ангиллын барилгын зураг төсөл төлөвлөхийг зөвшөөрөхгүй. “A”, “B”, “C” ангиллыг шинээр барих ба сэргээн засварласан барилгын зураг төслийг боловсруулах шатанд тогтооно.
- 8.6. Амины орон сууцыг ашиглалтад оруулах болон ашиглалтын явцад халаалт, агаар сэлгэлтийн дулааны эрчим хүчний хэрэгцээ нь нормын эсвэл зураг төслийн шатанд тогтоосон барилгын эрчим хүчний гэрчилгээний ангиллын шаардлагыг хангаж буй эсэхийг эрх бүхий барилгын эрчим хүчний аудитор болон магадлан итгэмжлэгдсэн аудитын байгууллага хянаж баталгаажуулна.



Зураг 15. Барилгын эрчим хүчний A ангиллын гэрчилгээтэй зураг (Жишээ зураг)


9. ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТТЭЙ АМИНЫ ОРОН СУУЦНЫ ЦОНХ, ШИЛЭН БАГЦЫН ҮЗҮҮЛЭЛТ

- 9.1. Эрчим хүчний хэмнэлттэй цонх нь Low-E буюу мөнгөжүүлсэн түрхлэгтэй түрхлэгтэй, аргон хийгээр дүүргэсэн, дулаалга сайтай зай баригч ашигласан байна.



Зураг 16. Эрчим хүчний хэмнэлттэй цонх (Жишээ зураг)


- 9.2. Эрчим хүчний хэмнэлттэй цонх, шилэн багц нь материалын сонголтоос хамаарч цонхны дулаан техникийн үзүүлэлт нь MNS 4753-2011 “Наамал шилэн багц техникийн ерөнхий шаардлага”, БНБД 25-01-20 “Барилгын дулаан хамгаалалт”-ын шаардлагыг хангасан байна.
- 9.3. Шилэн багцыг суурилуулахдаа шиллэгээ, заадал, үндсэн материал угсралтын дулаан алдагдлыг анхаарч төлөвлөнө.



Зураг 17. Эрчим хүчний хэмнэлттэй цонхны ханан дахь суулгалт (Жишээ зураг)

- 9.4. Том хэмжээний цонх төлөвлөх бол цонхны хүрээ жаазны нэмэлт хүчитгэгч хийцийг ашиглана.
- 9.5. Эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны цонхыг суурилуулахад нөлөөлөх хүчин зүйлс. Үүнд:
- гадна лент /псул/: Бороо, нарны туяа болон заадалд хуримтлагдах чийгийг чөлөөтэй гадагшлуулах;
 - суулгалтын чигжээс хөөс: гаднаас ирэх дуу чимээг тусгаарлаж, дулаан тусгаарлана;
 - уур чийг тусгаарлагч: Угсралтын заадлын хэсэгт чийг нэвтрүүлэхгүй, барилгын ханаар дамжсан чийгийг тасалгааруу нэвтрүүлэхгүй;
 - ус тусгаарлагч: Барилгын гаднах ханаар дамжих усыг угсралтын заадалд нэвтрүүлэхгүй.

- дулаалгын хөөсийг салхины шууд тусгалаас тусгаарласан байх;
 - дулаалгын хөөсийг гадна орчноос ус чийг тусгаарлалаар хангасан байх;
 - дулаалгын хөөсийг дотор тасалгаанаас уур чийг тусгаарлалаар хангасан байх.
- 9.6. Цонх, хаалга, хаалт гүйцэтгэгч нь дараах бичиг баримтын бүрдлийг хангасан байна:
- үйлдвэрлэгчийн чанарын гэрчилгээтэй;
 - хөндлөнгийн байгууллагаар натур туршигдсан дүгнэлттэй;
 - тохирлын гэрчилгээтэй;
 - эрчим хүчний аудиторын дүгнэлттэй байх.
- 9.7. MNS 4753-2011 “Наамал шилэн багц” стандартад заасны дагуу шилэн багцдаа эрчим хүчний хэмнэлттэй Low-E түрхлэгтэй шил, аргон буюу криптон хий хэрэглэж дээрх үзүүлэлтийг хангах ёстой.



- A. Solar Control / Нарны илч бууруулдаг
- B. Passive / Дулаан хадгалдаг
- C. Multifunctional - MF / Олон үйлдэлтэй

Зураг 18. Low-E шилний төрлүүд (Жишээ зураг)

(Тайлбар: “Low-E” Бага цацраг бүхий түрхэцтэй шил нь маш нимгэн, хүний нэг ширхэг үсийг 10,000 хуваасны нэгтэй тэнцэх хэмжээний нимгэн, энгийн нүдэнд харагддаггүй бөгөөд шилэн дээр шилний дулаан тусгаарлах үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор хэрэглэдэг.)

10. ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТТЭЙ ХАЛААЛТЫН ШИЙДЛҮҮД

- 10.1. Эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны халаалтын системийг шийдэхэд газрын байршил, барилгын зориулалт, төрөл, барилгын хэмжээс, давхаржилт, барилгын хашлага бүтээц, (гадна хана, хучилт, шал, цонх, гадна хаалга) дулаан хамгаалалт зэргийг харгалзан үзнэ.
- 10.2. Эрчим хүчний хэмнэлттэй халаалтын систем нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
- хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй байх;
 - дотор агаарын чанарт сөргөөр нөлөөлөхгүй байх;
 - цахилгаан, дулааны эрчим хүчийг бага зарцуулдаг байх;


- халаах хэрэгсэл нь дулаан тохируулагчтай байх;
- ухаалаг, автоматаар унтарч асдаг тохируулгатай байх;
- галын аюулгүй байдлыг хангасан байх;
- дуу чимээ багатай байх;
- ашиглалтын хугацаа урт байх;
- ухаалаг удирдлагын системд холбогддог байх;
- сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэртэй холбогддог байх;
- хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөгүй байх;
- эрчим хүчний хэмнэлттэй байх;
- халаагуурын үйлдвэрийн баталгаа, холбогдох чанар стандартын шаардлага хангасан гэрчилгээтэй байна.

10.3. Амины орон сууцны халаалтын системийн шийдлүүд:

Халаалтын систем нь дулааны насос, нарны халаалтын систем, газрын гүний дулаан, шалны халаалт, цахилгаан халаалт болон хийн зуух гэх мэт шийдлүүдтэй байж болно.

10.3.1. Дулааны насос:

Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр болох агаарыг ашиглан дулааныг үйлдвэрлэж айл өрхийн халаалтын системийг шийдэх боломжтой. Уг төхөөрөмжийн ажиллах зарчим нь гадна агаарын нам температурын дулаанаар дулааны насосын ажлын бие ууршиж, компрессороор шахагдан үүссэн дулаанаар халаалтын системийн ажлын биеийн температурыг нэмэгдүүлдэг. /Жишээ Зураг 19/



Зураг 19. Дулааны насосны ажиллагааны зарчмын схем

10.3.2. Нарны халаалтын систем:


Төвийн дулааны шугамаас алслагдсан барилга, байгууламж, хувийн орон сууц, жуулчны бааз зэргийн халаалт, халуун ус хангамжид нарны вакум коллекторт системийг ашиглавал тохиромжтой. Нарны вакум коллекторт халаалтын системийг суурилуулахад тухайн барилга нь жилийн туршид тэр дундаа өвлийн улиралд өдрийн туршид нар тусаж байхаар байгалийн болон зохиомол сүүдэрлэлтэд өртөхөөргүй байрлалд байвал зохино./ Жишээ Зураг 20/

Нарны усан халаалт



Зураг 20. Нарны халаалтын систем

- 10.3.3. **Газрын гүний дулаан:** Сэргээгдэх эрчим хүчний халаалтын технологиудаас хамгийн өндөр үр ашигтай технологи бол нөхөн сэргээгдэх нам температурын эх үүсвэртэй халаалтын систем буюу Газрын гүний дулааны халаалтын систем юм. Энэ нь дулааны насосоос бусад цахилгаан хэрэглээ багатай, хөлддөггүй зориулалтын дулаан дамжуулагч ашигладаг тул ажиллагаа сайтай ялтаст дулаан солилцууруудын насжилт өндөр байдаг.



Зураг 21. Газрын гүний дулаан

- 10.3.4. **Шалны халаалтын систем:** Шалны халаалтын системийг температурын жигд хуваарилалттай халаах хэрэгсэлтэй хослуулан хэрэглэх боломжтой. Шалны халаалтын системийг тооцоолохдоо агаарын урсгалын хурд, температурыг харгалзан үзнэ. Шалны халаалтын хоолой хоорондын зай 10-15см, нэг цагираг халаалтын шугам хоолойн урт хамгийн ихдээ 60м байвал зохимжтой.



Зураг 22. Шалны халаалтын систем (Жишээ зураг)

- 10.3.5. **Цахилгаан халаалтын систем:** Цахилгаан халаалтын систем нь усан халаалтын системийн эх үүсвэрийг цахилгаан зуухаар шийдэх, цахилгаанд залгах кабель болон плёнкон цахилгаан шалны халаалт, конвектор, хэт улаан туяаны халаагуур, шөнийн дулаан хадгалагч гэх мэт шийдлүүдтэй байдаг.

Цахилгаан халаалт нь дараах шаардлагуудыг хангасан байна. Үүнд:

- суурилуулж ашиглахад хялбар байх;

- автомат тохируулгатай байх;
- дуу чимээ багатай байх;
- эрчим хүчний хувьд хэмнэлттэй байх;
- ашиглалтын хугацаа урт байх;
- өрөөг хурдан халаадаг байх.

Цахилгаан халаагуур ашиглалтад дараах шаардлагыг мөрдөнө. Үүнд:

- халаалтын төхөөрөмж тэдгээрийн хоорондох зай нь 60 мм-ээс багагүй байх ба шатамхай материал хүртэлх зай 0.3 м-ээс багагүй байх;
- цахилгаан халаалтын системийн тоноглолууд нь шатамхай бус суурин дээр, эсвэл шатдаггүй дулаан тусгаарлагч материалаар хийсэн доторлогоотой байх;
- цахилгааны шит байрласан өрөөнд усан халаалтын систем төлөвлөхийг хориглоно.
- Хэрэглэгч нь халаагуурыг сонгохдоо үйлдвэрлэгчээс тогтоож өгсөн халаах талбай болон эзлэхүүний заалтыг зөрчихгүй, цахилгааны хүчин чадлаа зөв тохируулах шаардлагатай.

Хүснэгт 2. Цахилгаан халаалтын сонголт

Барилгын талбай, м2.	Цахилгаан халаагуур , кВт
60-200	25 хүртэл
200-300	25-35
300-600	35-60
600-1200	60-100

Цахилгаан халаалтын системийг сонгоход анхаарах зүйлс:

1. Гэр хороолол дахь тоолуурын нэгдсэн щитэд холбогдсон өрхийн тоолуур, автомат нь хамгийн дээд утгаараа 40А авах зориулалттай байдаг. Тиймээс 7.5 кВт-аас бага чадал шаардагдах цахилгаан халаагуур сонгохыг зөвлөө. Өөрөөр хэлбэл 7.5 кВт-аас дээш чадалтай халаагуур залгавал таны тоолуур шатах, автомат унах, эвдрэх болно. Цаашилбал цахилгаан эрчим хүч дамжуулж байгаа шугам сүлжээний найдвартай ажиллагаанд сөргөөр нөлөөлж, олон хэрэглэгчийн цахилгаан хангамж тасрахад хүргэдэг.
2. Нийт хэдэн кВт чадалтай халаалтын систем суурилуулснаас шалтгаалан таны сард төлөх цахилгааны мөнгө гарах тул энэ тоо бага байх нь зохимжтой бөгөөд мөн өрөөг халаах хэмжээний байх нь зүйтэй. Эрчим хүчний хэмнэлттэй халаалтын системүүд нь ийм боломжийг олгодог. Халаагуурын ашигт үйлийн коэффициент нь зарцуулж байгаа нийт цахилгааны хэдэн хувь нь яг өрөөг халаахад зарцуулагдаж байгааг илтгэнэ. Суурилуулахад хялбарыг сонгох нь цаг хугацаа, эд хөрөнгө хэмнэх давуу талтай юм.

3. Стандартын халаагуурууд ихэнхдээ шаталсан болон хугацааны тохируулгатай байдаг бөгөөд халаагуурын худалдан авалтыг хийхдээ энэ үзүүлэлтийг шалгаж аваарай. Энэ нь танд тохиромжтой дулаанаа хэрэглэх, цахилгааны мөнгийг хэмнэх, цаашлаад цахилгаан эрчим хүчийг үр ашигтай зарцуулахад ач холбогдолтой үзүүлэлт юм. Орчин үед технологийн дэвшилд тулгуурлан бүх зүйлс смарт болж байгаа билээ. Иймд өрөөний дулаанаа гар утсаараа алсаас удирдах боломжтой халаалтын систем нь бас нэгэн давуу тал болно. Халаалт бол хүний оролцоогүй ажиллаж байх ёстой.
4. Тухайн улсын стандартын шаардлагаас шалтгаалан бүтээгдэхүүний чанар харилцан адилгүй байдаг тул үйлдвэрлэсэн улсыг нь харах нь зүйтэй. Мэдээж баталгаат хугацаа их байх тусмаа тухайн бүтээгдэхүүний чанартайг илтгэх бөгөөд баталгаат хугацааны явцад эвдрэл болоход борлуулагч үнэ төлбөргүй засах эсвэл шинээр сольж өгөх давуу талтай.
5. Халаалтын системийн хувьд аюулгүй ажиллагаа нь маш чухал үзүүлэлт юм. Халаагуурыг худалдан авахдаа галын аюулгүй байдлыг хангах үүднээс ил улайсч байгаа хэсэг байхгүй, ахуйн зориулалтын халаагуурыг авах нь зүйтэй. Халаагуурын халаагч элемент нь улайсч халдаг бол агаарыг шатааж хуурайшуулж байна гэсэн үг. Тиймээс тийм төрлийн халаагуураас зайлсхийж, эрүүл мэнддээ анхаарах хэрэгтэй.
6. Сүүлийн үед цахилгаан халаагуур, бойлуурыг гар аргаар хийх нь ихсэж байгаагаас хүний амь нас, эд хөрөнгөд халтай олон сөрөг үр дагаврыг дагуулж байна. Шинээр тавьсан үедээ ямар ч аюулгүй мэт санагдах боловч эдэлгээний явцад чийгтэй нойтон байх, цахилгааны утас ил гарах, бүрээс нь урагдах, хүүхэд оролдох, санамсаргүй байдлаар аль нэг утас, холболт нь тасрах зэрэг нөхцөл үүсэхэд уг халаагуур нэн аюултай зүйл болон хувирдаг. Тиймээс үйлдвэрийн баталгааны бичиг, гэрчилгээтэй, стандартын шаардлага хангасан халаагуурыг сонгохыг зөвлөж байна.

11. СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ ШИЙДЭЛ

Өрхийн хэрэглээндээ сэргээгдэх эрчим хүч ашиглах бол дараах 3 төрлөөс сонгон суурилуулж болно.

11.1. On-grid буюу төвлөрсөн цахилгаан эрчим хүчний шугамтай зэрэгцээ ажиллах систем: Энэхүү системийн онцлог нь эрчим хүчээ нөөцлөх батарейгүй, нартай үед нарны эрчим хүчээс үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүчээ хэрэглэж, илүүдэл цахилгаанаа төвийн шугамд нийлүүлдэг. Төвийн цахилгаан эрчим хүчний шугамд холбогдсон хот суурин газарт тохиромжтой.

Төвлөрсөн сүлжээтэй зэрэгцээ ажиллах систем /Ongrid solar system/



Давуу тал:

- Эрчим хүчний хэмнэлт
- Энгийн тохиргоотой
- Цахилгаан борлуулах боломжтой
- Байгаль орчинд ээлтэй
- Үнэ цэнээ алдахгүй


Сул тал:

- Төвлөрсөн сүлжээгээр дэмжиж ажилладаг
- Бие дааж ажиллахгүй

Зураг 23. Төвлөрсөн сүлжээтэй зэрэгцээ ажиллах ongrid систем (Жишээ зураг)

11.2. Offgrid буюу бие даасан батерейтай систем: Өдрийн туршид нарнаас ирэх эрчим хүчээ шууд ашиглах болон батерейндаа эрчим хүчээ нөөцлөн шөнийн хэрэглээндээ ашигладаг. Цахилгаан хуримтлуур буюу батерейтай тул анхны хөрөнгө оруулалт өндөртэй байдаг. Энэхүү системийг төвийн цахилгаан шугамаас алслагдсан айл өрх, жуулчны баазууд ашиглавал зохино.

Бие даасан батерейтай систем /Offgrid solar system/



Давуу тал:

- Найдвартай эрчим хүч
- Төвийн сүлжээнд холбогдоогүй б даасан
- Бие даан тодорхой хугацаанд ажиллана
- Байгаль орчинд ээлтэй


Сул тал:

- Үнэ өртөг өндөр
- Цахилгаан борлуулах боломжгүй
- Хязгаарлагдмал

Зураг 24. Бие даасан батерейтай offgrid solar систем (Жишээ зураг)

11.3. Hybrid буюу Хосолмол систем: Төвийн цахилгааны шугамтай зэрэгцээ болон бие даасан байдлаар хослон ажиллах нарны эрчим хүчний систем юм. Энэхүү системийг эрчим хүчний тасралтгүй байдлыг хангах шаардлагатай онцгой объектууд эмнэлэг, банк, дата төв зэрэг газруудад суурилуулахад тохиромжтой.

Хосолмол систем /Hybrid solar system/



Зураг 25. Хосолмол Hybrid solar систем (Жишээ зураг)

(Тайлбар: Эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцанд барилгын эрчим хүчний гэрчилгээний хэмнэлтийн хувиас гадна нэмэлтээр өрхийн цахилгаан хэрэглээндээ сэргээгдэх эрчим хүч суурилуулсан тохиолдолд хэрэглэгчийн сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрээс үйлдвэрлэсэн эрчим хүчийг түгээх сүлжээнд нийлүүлэх журмын дагуу үйлдвэрлэсэн илүүдэл эрчим хүчээ түгээх сүлжээнд нийлүүлж, ашиглалтын зардлыг 0 хувь хүртэл бууруулах боломжтой.)

11.4. Хэрэглэгч нь тоног төхөөрөмжийн угсралт, засвар, үйлчилгээг тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдээр гүйцэтгүүлнэ.

11.5. Цахилгаан эрчим хүч хэрэглэх техникийн шаардлагыг хангасны үндсэн дээр түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигчээс бага оврын үүсгүүр суурилуулах тухай техникийн нөхцөл авсан байна.

12. ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТТЭЙ АГААРЖУУЛАЛТЫН СИСТЕМ

12.1. Эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууц нь битүүмжлэл өндөртэй, дулаан алдагдал багатай байдаг тул энэ төрлийн амины орон сууцанд эрчим хүчний хэмнэлттэй агааржуулалтын систем зайлшгүй төлөвлөх шаардлагатай.

12.2. Агаар сэлгэлтийн систем эрүүл ахуй, технологийн шаардлагыг хангахаас гадна эрчим хүчний хувьд хэмнэлттэй, хүрээлэн буй орчинд ээлтэй, эдийн засгийн хувьд үр ашигтай байх шийдлийг төлөвлөвөл зохимжтой.

12.3. Агаар дахь түгээмэл тархацтай бохирдуулах бодисын хүлцэх агууламж болон физикийн сөрөг нөлөөллийн зөвшөөрөгдөх дээд хэмжээг MNS 4585:2016 " Агаарын чанар Техникийн ерөнхий шаардлага"-д нийцүүлнэ.






Зураг 29. Амины сууцны агаар сэлгэлтийн ерөнхий зарчим (Жишээ зураг)

- 12.4. Эрчим хүчний хэмнэлттэй агааржуулалтын системийн шийдэлд дараах шаардлагыг баримталбал зохино. Үүнд:
- хөгц, мөөгөнцөр үүсэхээс сэргийлж тоос тоосонцор, нүүрсхүчлийн давхар исэл, чийгшил тэнцвэржүүлэх тохируулгатай байх;
 - эрчим хүчний зарцуулалт багатай, гар утаснаасаа ухаалаг удирдлагын системд холбогддог байх;
 - ашиглалтын явцад дуу чимээ багатай байх;
 - нян бактери үрждэггүй байх;
 - өвлийн улиралд дулаанаа хадгалж, зуны улиралд сэрүүнээ хадгалах боломжтой байх;
 - хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй байх;
 - дотор агаарын чанарыг хэмжих мэдрэгчүүдтэй байх;
 - хэрэглэх болон ашиглахад хялбар байх;
 - галын аюулгүй байдлыг хангасан байх;
 - ашиглалтын хугацаа урт байх;
 - хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөгүй байх;
 - агаар сэлгэлтийн төхөөрөмжийн үйлдвэрийн баталгаа, холбогдох чанар стандартын шаардлага хангасан гэрчилгээтэй байх;

АЖИЛЛАХ ЗАРЧИМ

Агааржуулагчийн эргэлт буцалтгүй ажиллагаа нь эрчим хүчийг нөхөн сэргээх боломжийг олгодог хоёр мөчлөгөөс бүрдэнэ:



Зураг 26. Эрчим хүчний хэмнэлттэй агааржуулалтын ажиллах горим (Жишээ зураг)


(Тайлбар: Хүйтэн болох буюу гадна агаарын температур буурах тусам даралтын зөрүү нэмэгдэж их хэмжээний хүйтэн агаар нээлхийгээр орж ирдэг тул агаар оруулах талбайг ихэсгэж багасгаж тохируулдаг байх. Уг шийдэл нь шүүлтүүртэй байх бөгөөд тоос, шороо шүүх зориулалттай G3 төрлийн шүүлтүүр, утаа буюу PM2.5 нарийн тоосонцрыг шүүх зориулалттай F7 төрлийн шүүлтүүрийг ашигладаг. Харин өвлийн улирал буюу агаарын бохирдол ихтэй үед G3, F7 шүүлтүүрүүдийг цуг ашиглах нь тохиромжтой бөгөөд G3 төрлийн шүүлтүүрийг нь гадна талдаа байхаар байрлуулдаг бол бусад саруудад зөвхөн G3 шүүлтүүрээ ашигладаг. Шүүлтүүрүүдийг 3 сар тутамд соливол зохино.)



15-50 м³/цаг бүтээлтэй
ялтсан дулаан
солилцууртай оруулах
болон зайлуулах
төхөөрөмж

16-46 м³/цаг
бүтээлтэй
ялтсан дулаан
солилцууртай

20-50 м³/цаг
бүтээлтэй оруулах
төхөөрөмж



Зураг 30. Эрчим хүчний хэмнэлттэй агаар сэлгэлтийн шийдэл

12.5. Агааржуулалтын системийг сонгохдоо дараах үндсэн параметруудийг тооцоолно.

Үүнд:

- агаар дахь бүтээмж; агаарын халаагчийн хүч;
- сэнснээс үүссэн ажлын даралт;
- агаарын урсгалын хурд ба сувгийн хөндлөн огтлолын талбай;
- дуу чимээ зөвшөөрөгдөх түвшин.

13. ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТТЭЙ, БОХИРЫН ЦЭВЭРШҮҮЛЭХ СИСТЕМ

- 13.1. Инженерийн төвлөрсөн шугам сүлжээнд холбогдох боломжгүй байршилд UCS 0702B:2023 “Бохир усны цооног, Бие даасан цэвэрлэх байгууламж” хотын стандартын дагуу төлөвлөвөл зохино.
- 13.2. Бие даасан цэвэрлэх байгууламж, септиктэй иж бүрдэл болгож шүүрүүлэх худаг, талбай, туннел, элс хайрган шүүлтүүр, суваг зэргийг тухайн хөрсний шинж чанарт тохируулсан байдлаар сонгоно.
- 13.3. Бохирын систем нь тунгаагч сав буюу сепик танк, шүүлтүүрийн хэсэг, шингээгч хэсэг гэсэн 3 үндсэн хэсгээс бүрдэнэ. Системийн зорилго нь бохир хаягдлыг ялган задалж, ялгарч тунасан шингэн хэсгийг нь газрын хөрсөөр дамжуулан цэвэршүүлэн шүүж, хөрсний устай дүйцэхүйц хэмжээнд хүртэл усыг цэвэршүүлэх шаардлагатай.
- 13.4. Септикийг төлөвлөхөд шаардлагатай байгаль, цаг уурын нөхцөл болон бусад өгөгдлүүдийг БНБД 40-01-14 “Ариутгах татуурга.Гадна сүлжээ ба байгууламж” барилгын норм дүрмийн дагуу MNS EN 12566-1:2011 “50 хүртэл хүн амд зориулсан бага хүч чадлын ахуйн бохир ус цэвэрлэх байгууламж 1-р хэсэг. Угсармал септик, MNS EN 12566-2 : 2011 50 хүртэл хүн амд зориулсан бага хүч чадлын ахуйн бохир

ус цэвэрлэх байгууламж 2-р хэсэг. Хөрсөөр шүүрүүлэх систем стандартад нийцүүлэн төлөвлөнө.

- 13.5. Септик системийн ажлыг байршил бүрд хөлдөлтийн түвшин, хөрсний ус шүүрүүлж шингээх чадамж, хад асга, цэвдэг зэрэг үзүүлэлтүүдийг урт хугацаандаа эрсдэлгүй байх тооцоолол хийж, албан ёсны зураг төслийн дагуу мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ.
- 13.6. Эрчим хүчний хэмнэлттэй, дэвшилтэт бохирын цэвэршүүлэх систем нь дараах шаардлагыг хангасан байвал зохино. Үүнд:
 - хүйтний улиралд хөлдөхгүй, соруулахгүй, үнэргүй, хөрсийг бохирдуулдаггүй байх;
 - намагтай, цэвдэгтэй, хадархаг бүх төрлийн хөрсний онцлог хэрэглэгчийн хэрэглээнд тохирсон шийдэлтэй байх;
 - цахилгаан зарцуулалт багатай байх;
 - тусгай зөвшөөрөл болон холбогдох чанар стандартын сертификаттай байх;
 - ашиглалтын үеийн засвар үйлчилгээ үзүүлэх зааварчилгаатай байна.



Зураг 32. Эрчим хүчний хэмнэлттэй бохирын систем ажиллах горим (Жишээ зураг)

- 13.7. Цэвэршүүлсэн бохир усыг байгальд нийлүүлэх бол MNS 4943:2015 “Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага” стандартын шаардлагыг хангасан байна.
- 13.8. Цэвэршүүлсэн бохир усыг дахин ашиглахад MNS BS 8525-1:2015. “Саарал усны систем”, MNS ISO 16075 “Цэвэрлэсэн хаягдал усыг усалгаанд ашиглах заавар” стандартыг дагаж мөрдөнө.

14. ЦАХИЛГААН ХАНГАМЖИД ТАВИХ ШААРДЛАГА

- 14.1. Цахилгааны угсралтыг зураг төслийн дагуу БНБД 3.05.06-90 “Цахилгаан техникийн ажил” нормын шаардлагад нийцүүлэн гүйцэтгэнэ.
- 14.2. Нэг айлын орон сууцыг эрчим хүчээр хангагч байгууллагын техникийн нөхцөлийн дагуу цахилгааны дэд өртөөнөөс 0,4 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын болон кабель шугамаар холбогдох техникийн нөхцөлийг үндэслэн төлөвлөнө.
- 14.3. Барилгын цахилгаан эрчим хүчний тоолуур бүхий оролтын самбарыг түүний гадна эсхүл дотор төлөвлөхдөө шалнаас дээш 1,5 м-ийн өндөрт газардуулгатай байна.

- 14.4. Оролтын самбарт цахилгаан зуух, хүчний розетка, гэрэлтүүлэг зэрэг 3 групп төлөвлөнө.
- 14.5. Барилгын дотор монтажийг ил болон далд галд тэсвэртэй зэс голчтой утас, кабелиар угсралтыг хийж гүйцэтгэнэ.
- 14.6. Барилга байгууламжийг орчны нөхцөлөөс хамаарч аянга хамгаалалтыг хийж газардуулгатай холбож өгнө.
- 14.7. Барилгын цахилгаан тоног төхөөрөмжийг сонгоходоо үйлдвэрлэгчийн гэрчилгээтэй материал сонгоно.
- 14.8. Эдэлбэр газрын төлөвлөлттэй уялдуулан гадна гэрэлтүүлэг нь эрчим хүчний хэмнэлттэй гэрэлтүүлэг байна.
- 14.9. 0,4 кВ-ын кабель шугамыг газрын тэгшлэгдсэн түвшингээс доош хамгийн багадаа 0,7 м-ийн гүнд тавьж угсралтын ажлыг хийж гүйцэтгэнэ.
- 14.10. Эрчим хүчний шугам сүлжээний хамгаалалтын зурвас нь 0,4 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын захын утаснаас хоёр тийш 1-1,5 метр, кабель шугамаас хоёр тийш 1 метр байна.
- 14.11. Газардуулгийн байгууламжийн эсэргүүцэл 1 фазын гүйдлийн үүсгүүрт 220В, 380В байхад жилийн аль ч улиралд харгалзан 4 Ом-ээс илүүгүй байна.
- 14.12. Нэг фазын бүлгийн шугам 3-утагст, хоёр фазын бүлгийн шугам 4-утагст, 3 фазын бүлгийн шугам 5-утагст, тусдаа N ба РЕ дамжуулагчтай гүйцэтгэнэ.
- 14.13. Хүүхдийн өрөөнд залгуур сугалахад үүрийг нь хаадаг хамгаалалтын тоноглолтой разеткийг байрлуулах нь зүйтэй.
- 14.14. Цахилгаан халаах хэрэгсэл ба барилгын хийц хооронд 60 мм-ээс багагүй зайтай байна.
- 14.15. Барилгажилтын талбай нь 150 мм кв-аас илүүгүй, 7м хүртэл өндөртэй металл бус дээвэртэй жижиг барилгын аянга хамгаалалтыг хялбарчилсан аргаар хийж болно.
- 14.16. Банз модонд 5мм-ийн голчтой ган утас хадаж, барилгын дээврийн дээд ирмэгээс 250мм-ийн зайд байрлуулна.

15. ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

- 15.1. Гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмж (галын автомат систем. ус хангамж г.м)-ийг ашиглалтын байнгын бэлэн байдалд байлгана.
- 15.2. Эдэлбэр газар дахь барилга байгууламж болон орон сууц, бусад барилгын хооронд төлөвлөгдсөн галын аюулгүйн зайд /хамгийн багадаа 8м/ байгаа шатамхай хог хаягдлыг тухай бүр цэвэрлэнэ.
- 15.3. Эдэлбэр газарт амьдарч буй өрх бүр гал гарсан үед ашиглах багаж хэрэгсэлтэй байна (гал унтраагуур, хүрз, хувин, дэгээ, эсгий, цохиур г.м).
- 15.4. Аврах гарцтай, галд тэсвэршилтийн II зэргээс доошгүй байна.
- 15.5. Цахилгаан дамжуулалтад хэрэглэгдэх утас, кабелин тусгаарлалт нь түүнийг сунгах арга, орчин нөхцөлтэй тохирч байх ёстой.
- 15.6. Гал тэсвэршилтийн I, II, III зэрэгтэй амины орон сууцны барилгын даацын бус хана болон барилгын хонгил, өрөө тасалгааг хооронд нь зааглаж байгаа хана, хамар ханын гал тэсвэршилтийн хязгаар 0.75 цагаас багагүй байна.
- 15.7. Сууцны барилгын хийц бүтээц нь гал тархдаггүй материалаар хийгдсэн байна.
- 15.8. Төвлөрсөн шугам сүлжээнд холбогдоогүй тохиолдолд гал унтраах усны нөөц сав буюу усан санг ашиглах боломжийг зураг төсөлд тусгахыг зөвшөөрнө.
- 15.9. Төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон тохиолдолд эдэлбэр газрын гадна гал

унтраах ус хангамжийн шугам сүлжээг холбогдох нормын шаардлагын дагуу төлөвлөнө.

- 15.10. Нэг айлын сууц нь галын аюулын Ф1.4 ангид хамаарна. Ямар ч төрлийн барилга байгууламжид барилгаас гадагш гарах гарцыг төлөвлөсөн байна.
- 15.11. Зэрэгцүүлэн барьсан сууцны блок болон хоёр ба түүнээс дээш автомашины битүү зогсоотой тохиолдолд сууцны өрөө тасалгаа нь REI 45-аас доошгүй гал тэсвэршилтийн хязгаартай материалаар хийгдсэн хамар ханаар тусгаарлах ба энэ нь галын аюулын анги Г1-ээс багагүй байна.
- 15.12. Давхар сууцны үндсэн хийц бүтээц нь гал тэсвэршилтийн III зэрэгтэй нийцэж байвал зохино.
- 15.13. Давхрын талбайн хэмжээ нь 150 м²-аас бага тохиолдолд даацын элементүүдийн гал тэсвэршилтийн хязгаар нь P30-аас, хучилт нь REI30-аас багагүй байна.

16. АМИНЫ ОРОН СУУЦНЫ ЭДЭЛБЭР ГАЗАРТ ТАВИХ ШААРДЛАГА

- 16.1. Талбайн бэлтгэл ажил: Эдэлбэр газрын налуу нь 8 градусаас доош талбайд газрыг сэтэлж барилга барихдаа ханын бэхэлгээг зайлшгүй хийнэ. Эргэн тойрны гудамжинд үерийн ус зайлуулах байгууламжгүй, эдэлбэр газрын гадаргын налуу 8 градусаас дээш тохиолдолд хашааны дотор талбайд үер, хур ба усыг залах суваг хийж барилгын дээвэрт борооны ус цуглуулах хоолойг тоноглож усыг цуглуулах боломжийг бүрдүүлнэ.
- 16.2. Хэрэв хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд тодорхой тусгаагүй тохиолдолд барилгажилтын талбайн хэмжээг эдэлбэр газрын хэмжээнээс нь хамааруулан нийт талбайн (30-40) хувь байхаар тогтооно.

Хүснэгт 3. Амины орон сууцны эдэлбэр газрын төлөвлөлт

№	Эдэлбэр газрын хэмжээ (м ²)	Барилгажилтын талбайн эзлэх хувь
1.	700 хүртэл	40 хүртэл
2.	701-ээс дээш	30 хүртэл

- 16.3. Амины болон хэд хэдэн айлын сууцны барилгыг гудамжны улаан шугамаас 5 м-ээс багагүй, нэвтрэх замын улаан шугамаас 3 м-ээс багагүй зайд төлөвлөвөл зохино.
- 16.4. Амины сууцны барилгын өнгө үзэмж, тохижилтын архитектур шийдэл нь орчны барилгажилт, хотхоны шийдэлтэй уялдсан байна.
- 16.5. Мал аж ахуй эрхлэх зөвшөөрсөн нутаг дэвсгэрт мал, шувууны байр, өвс тэжээлийн саравч, аж ахуйн бусад барилга, төлөвлөхийг зөвшөөрнө.
- 16.6. Амины орон сууцын өрөө тасалгааны цонхноос зэргэлдээ эдэлбэр газарт байрлах хөрш айлын сууцны барилгын хана ба туслах аж ахуйн барилга (саравч, пин, гараж г.м) хүртэлх зай 6 м-ээс багагүй байх.



Зураг 27. Нэг айлын эдэлбэр газрын төлөвлөлт (Жишээ зураг)



Зураг 34. Нэг айлын эдэлбэр газрын төлөвлөлт (Жишээ зураг)

17. АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

- Монгол Улсын Үндсэн Хууль;
- Хот байгуулалтын тухай;
- Барилгын тухай;
- Газрын тухай хууль;
- БНБД 25-01-20 - Барилгын дулаан хамгаалалт (2021);
- UCS1105B:2023 - “Амины орон сууцны төлөвлөлт, ашиглалтад тавих шаардлага” хотын стандарт;
- UCS 1501C:2023 “Хаалга, цонхонд тавих ерөнхий шаардлага ” – Хотын стандарт;
- UCS 0702B:2023 “Бохир усны цооног, Бие даасан цэвэрлэх байгууламж”, Хотын Стандарт;
- БНБД11-04-16 - Барилгын ажилд зураг төсөл зохиогчийн хяналт тавих дүрэм;
- БНБД 21-01-02 - Барилга байгууламжийн галын аюулгүй байдал;
- БНБД 21-02-02- Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүй норм;
- БНБД 31-09-07 - Нэг айлын орон сууцны барилгын төлөвлөлт ба угсралт;
- БНБД 23-02-08 - Байгалийн ба зохиомол гэрэлтүүлэг;
- БНБД 3.05.06-9 - Цахилгаан техникийн ажил;
- БД 31-112-11- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах орчны шаардлага нийцсэн зураг төсөл зохиох дүрэм;
- БД 43-101-03 - Цахилгаан байгууламжийн дүрэм;
- БД 31-117-15 - Дээврийн хучлага төлөвлөх ба гүйцэтгэх;
- БНБД 41-01-02 - Халаалт, агаар сэлгэлт ба кондиционер;
- MNS 6877:2020 - “Гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын ашиглалтад тавих ерөнхий шаардлага”;
- MNS 6266:2011 - “Барилгын хана, цонхны уулзварын угсралтын заадал” Техникийн ерөнхий шаардлага;
- MNS ISO 16000 - 40:2023 Дотор орчны агаарын чанарын менежментийн тогтолцоо;
- MNS ISO 9972 - Барилгын дулаан хамгаалалт-Барилгын агаар нэвтрүүлэлтийг тодорхойлох, сэнсээр даралт үүсгэх арга;
- MNS 4585:2016 - “Агаарын чанар Техникийн ерөнхий шаардлага”;
- Ногоон барилгын төлөвлөлт ном (2018);
- Giz Эрчим хүчний үр ашиг каталоги (2022)
- “Монголын амины орон сууцны инновац хөгжлийн төв”-Эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны чадавхжуулах сургалтын материал
- СП 60.13330.2020 Отопление, вентиляция и кондиционирование воздуха
- HVAC Systems Design Handbook by Roger W. Haines and C. Lewis Wilson
- “ASHRAE Standard 90.1: Energy Standard for Buildings Except Low-Rise Residential Buildings” by American Society of Heating, Refrigerating and Air-Conditioning Engineers
- “NFPA 90B: Standard for the Installation of Warm Air Heating and Air-Conditioning Systems”

- “Energy-Efficient Building Systems: Green Strategies for Operation and Maintenance”
Lal Jayamaha and Ronald J. Kim